# МОНГОЛ ДААТГАЛ ХК

Санхүүгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31
(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

# МОНГОЛ ДААТГАЛ ХК

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд: | Борисович Громов Сергей<br>Сэдбазарын Отгонбат<br>Батмөнхийн Мөнхзул<br>Сиваев Александр Владимирович<br>Лизунова Таня<br>Огай Наталья Юрьевна<br>Энхсайханы Алтанзул<br>Ишхүүгийн Дариймаа<br>Жамбалын Эрдэнэтуяа |
| Гүйцэтгэх захирал: | Энхсайханы Алтанзул |
| Стратеги, бизнес хөгжлийн удирдлага хариуцсан захирал: | Чинбатын Одонгэрэл |
| Албан хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж, Түшиг төв, 1 давхар, 101 тоот<br><br>Утас: +976 9980 2732, +976 9919 0032<br>Вэб хаяг: www.mongoldaatgal.mn |
| Хараат бус аудиторууд: | Нексиа Глобал Монголиа Аудит ХХК<br>Мэргэшсэн нягтлан бодогчид |

Нексиа Глобал Монголиа Аудит ХХК
Эмбасси Уан Бюлдинг, 606 тоот, 6-р давхар,
Элчингийн гудамж, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар, Монгол Улс

Утас: +976 7700 1500,
Веб хаяг: www.nexia.com

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МОНГОЛ ДААТГАЛ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

### Аудиторын дүгнэлт

Бид Монгол Даатгал ХК (цаашид "Компани" гэх)–ийн 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)–ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

### Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"–ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

**НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид:

**Э.БУЛГАН**
Партнер

**У.НАРАНДЭЛГЭР**
Аудитор

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

# МОНГОЛ ДААТГАЛ ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## ХАВСРАЛТ 1

## 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

| (Мянган төгрөгөөр) | 2025 | 2024 |
|---|---|---|
| Даатгалын хураамжийн нийт орлого | 22,908,854 | 23,879,610 |
| Даатгалын хураамжийн буцаалт | (645,544) | (648,644) |
| Давхар даатгалын хураамжийн зардал | (5,394,135) | (4,269,766) |
| Даатгалын хураамжийн цэвэр орлого | 16,869,175 | 18,961,200 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт | 430,201 | 1,659,499 |
| Хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлт | (90,667) | (2,119,911) |
| Орлогод тооцсон хураамж | 17,208,709 | 18,500,788 |
| Нийт нөхөн төлбөрийн зардал | (8,304,292) | (15,262,779) |
| Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр | 334,129 | 5,706,040 |
| Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр | 292,896 | 593,579 |
| Нөхөн төлбөрийн цэвэр зардал | (7,677,267) | (8,963,160) |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт | (96,241) | 85,834 |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт | 95,158 | (32,426) |
| Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт | (138,791) | 49,184 |
| Зардалд тооцсон нөхөн төлбөр | (7,817,141) | (8,860,568) |
| Даатгалын гэрээний зардал | (3,413,992) | (3,343,292) |
| Давхар даатгалын шимтгэлийн орлого | 236,316 | 303,437 |
| Хөрөнгө оруулалтын олз, гарз | 1,751,274 | 1,157,224 |
| Даатгалын үйл ажиллагааны ашиг / (алдагдал) | 7,965,166 | 7,757,589 |
| Түрээсийн орлого | 182,261 | 167,157 |
| Хүү, Эрхийн шимтгэлийн орлого | 8,661 | 40,831 |
| Бусад орлого | 51,751 | 34,508 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (4,940,566) | (5,060,912) |
| Борлуулалт, маркетингийн зардал | (5,371,226) | (5,437,931) |
| Санхүүгийн зардал | (392,761) | (2,602) |
| Бусад зардал | (471,342) | (1,194,132) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз / (гарз) | 47,493 | (23,110) |
| Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз / (гарз) | 3,536,211 | 29,926 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал) | 615,648 | (3,719,971) |
| Орлогын албан татварын зардал | (153,030) | (110,063) |
| Тайлант жилийн цэвэр ашиг | 462,618 | (3,830,034) |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК ХУУДАС

# МОНГОЛ ДААТГАЛ ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ХАВСРАЛТ 2

## 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

| (Мянган төгрөгөөр) | 2025-12-31 | 2024-12-31 |
|---|---|---|
| ХӨРӨНГӨ | | |
| Эргэлтийн хөрөнгө | | |
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 1,326,486 | 1,426,929 |
| Даатгалын авлага | 1,326,084 | 907,541 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 2,162,332 | 1,823,487 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 1,216,498 | 717,889 |
| Хөрөнгө оруулалт | 9,882,967 | 10,366,054 |
| Даатгалын хөрөнгө | 3,895,241 | 3,709,458 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 19,809,608 | 18,951,358 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгө | 6,612,164 | 8,080,438 |
| Биет бус хөрөнгө | 1,369,049 | 1,370,388 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 7,981,213 | 9,450,826 |
| НИЙТ ХӨРӨНГӨ | 27,790,821 | 28,402,184 |
| Өр төлбөр ба эздийн өмч | | |
| ӨР ТӨЛБӨР | | |
| Даатгалын өглөг | 410,765 | 1,569,457 |
| Санхүүгийн өр төлбөр | 1,208,153 | 1,669,802 |
| Санхүүгийн бус өр төлбөр | 989,406 | 236,698 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц | 9,910,246 | 10,351,627 |
| Нөхөн төлбөрийн нөөц сан | 5,957,374 | 5,722,341 |
| Нийт өр төлбөр | 18,475,944 | 19,549,925 |
| ЭЗДИЙН ӨМЧ | | |
| Хувьцаат капитал | 6,413,234 | 6,413,234 |
| Халаасны хувьцаа | (9,857) | (9,857) |
| Нэмж төлөгдсөн капитал | 4,523 | 4,523 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 7,038,876 | 7,038,876 |
| Хуримтлагдсан ашиг | (4,131,899) | (4,594,517) |
| ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 9,314,877 | 8,852,259 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 27,790,821 | 28,402,184 |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

## ХАВСРАЛТ 3

## 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

| (Мянган төгрөг) | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Халаасны хувьцаа | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлаг дсан ашиг | Нийт эздийн өмч |
|---|---|---|---|---|---|---|
| 2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл | 6,413,234 | 4,523 | (9,857) | 7,038,876 | (764,483) | 12,682,293 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 6,413,234 | 4,523 | (9,857) | 7,038,876 | (764,483) | 12,682,293 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | (3,830,034) | (3,830,034) |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | - |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - |
| 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 6,413,234 | 4,523 | (9,857) | 7,038,876 | (4,594,517) | 8,852,259 |
| Шинээр хэрэгжүүлсэн стандартууд | | | | | | |
| 2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл | 6,413,234 | 4,523 | (9,857) | 7,038,876 | (4,594,517) | 8,852,259 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | 462,618 | 462,618 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - |
| 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 6,413,234 | 4,523 | (9,857) | 7,038,876 | (4,131,899) | 9,314,877 |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

# МОНГОЛ ДААТГАЛ ХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## ХАВСРАЛТ 4

## 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МАЯГТЫН ДАГУУХ ТОЛИЛУУЛГА

| (Мянган төгрөгөөр) | Тод | 2025 | 2024 |
|---|---|---|---|
| ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | |
| Даатгалын хураамжийн орлого | | 18,515,449 | 21,112,284 |
| Давхар даатгалын нөхөн төлбөр | | - | 5,714,987 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | - | 40,831 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | 814 | 595,184 |
| Бусад мөнгөн орлого | | 22,768,914 | 1,317,192 |
| Мөнгөн орлого | | 41,285,177 | 28,780,478 |
| Ажиллагсдад төлсөн | | 3,755,011 | 5,227,649 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | | 317,424 | 1,078,439 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | | 32,450 | 75,604 |
| Ашиглалтын зардалд төлсөн | | 673,680 | 180,026 |
| Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж | | 2 | 9,949,345 |
| Нөхөн төлбөрт төлсөн | | 6,852,458 | 15,262,779 |
| Даатгалын төлөөлөгчийн шимтгэл | | 2,760,766 | 2,726,705 |
| Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр | | 763,973 | 737,613 |
| Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр | | - | 785 |
| Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | | 6 | 376,392 |
| Хүүний төлбөрт төлсөн | | - | - |
| Татварын байгууллагад төлсөн | | 1,520,972 | 745,056 |
| Даатгалын төлбөрт төлсөн | | 400 | 10,000 |
| Бусад мөнгөн зарлага | | 16,231,011 | 1,903,405 |
| Мөнгөн зарлага | | 35,323,432 | 34,481,893 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | 5,961,745 | (5,701,415) |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | - | - |
| Хүлээн авсан хүүгийн орлого | | 26,500 | 922,428 |
| Хүлээн авсан ногдол ашиг | | - | 143,850 |
| Мөнгөн орлого | | 26,500 | 1,066,278 |
| Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн | | - | 72,703 |
| Мөнгөн зарлага | | - | 72,703 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | 26,500 | 993,575 |
| САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн | | - | 1,279,100 |
| Мөнгөн орлого | | - | 1,279,100 |
| Бусад | | 6,088,688 | - |
| Мөнгөн зарлага | | 6,088,688 | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | (6,088,688) | 1,279,100 |
| Цэвэр мөнгөн гүйлгээ | | (100,443) | (3,428,740) |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 15 | 1,426,929 | 4,855,669 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 15 | 1,326,486 | 1,426,929 |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
66
ХУУДАС